



Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх
ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



Дотоод хэргийн их сургуулийн
ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛЬ

“Гамшигт тэсвэртэй дэд бүтэц –Disaster Resilient Infrastructure” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Хугацаа:

2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

Зохион байгуулагдах газар:

Монгол Улс, Улаанбаатар хот, Онцгой байдлын ерөнхий газар

Зохион байгуулагч:

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн

Хамтран зохион байгуулагч:

ДХИС-ийн Онцгой байдлын сургууль

Нэг. Үндэслэл

Монгол орны газарзүй, нийгэм, эдийн засгийн өвөрмөц байдал нь гамшгийн эрсдэлийн онцгой нөхцлийг бүрдүүлж байдаг. Тухайлбал, зуд, их хэмжээний цасан болон мөсөн бүрхүүл тогтох, хүчтэй салхи, шуурга, үер, ой, хээрийн түймэр, ган зэрэг байгалийн аюул жил бүр тохиолдож, хүн амын ахуй амьдрал, улс орны эдийн засаг, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Үүний зэрэгцээ Монгол Улс нь төв Азийн газар хөдлөлтийн өндөр идэвхжилтэй бүс нутагт байрладаг бөгөөд сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн давтамж улам бүр нэмэгдэх боллоо. Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх нь Монгол Улсын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төр, засгийн бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн нэгд тооцогдож байна.

Нэгдсэн үндэстний байгууллагаас Уур амьсгалын өөрчлөлтийн талаар 2019 онд зохион байгуулагдсан дээд хэмжээний уулзалтын үеэр Энэтхэгийн ерөнхий сайд санаачлан Гамшигт тэсвэртэй дэд бүтцийн эвсэл(CDRI)-ийг байгуулсан. Эвслийн гишүүнээр 47 орон нэгдсэн байдаг ба тэдний нэг нь Монгол Улс юм. Гамшигт тэсвэртэй дэд бүтэц эвслийн зорилго нь “Ирээдүйн гамшиг болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг байгуулахад системтэйгээр дэмжлэг үзүүлэх юм. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн Парисын гэрээ, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байх” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Гамшигт тэсвэртэй дэд бүтэц эвсэлд нэгдэн орсон нь Засгийн газрын түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах нь тогтвортой хөгжлийн үндэс болохыг

тэр дундаа гамшигт тэсвэртэй дэд бүтцийг байгуулах асуудлаар дээд түвшний манлайлал үзүүлж, ихээхэн анхаарал хандуулж байгаагийн илэрхийлэл гэж үзэж болно.

Нийгэм эдийн засгийн хөгжил, хотжилт эрчимтэй явагдаж буйтай холбоотойгоор хот суурин газруудын гамшигт тэсвэртэй байдлыг хангах, барилга, байгууламж, дэд бүтцийг илүү сайжруулан барьж байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд төрийн зүгээс онцгой анхаарал хандуулж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь хэрэгжих шатандаа олон асуудалтай тулгарч байна. Эдгээр асуудлыг шийдэхэд бүх талуудын мэдлэг, ойлголт, оролцоо, нэн ялангуяа шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн, судлаачдын үүрэг оролцоо онцгой чухал гэж үзэж энэ удаагийн хурлыг санаачлан зохион байгуулж байна.

Хоёр. Хурлын зорилго

- Гамшигт тэсвэртэй дэд бүтцийг илүү сайжруулан барьж байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх;
- Гамшигт тэсвэртэй дэд бүтцийг илүү сайжруулан барьж байгуулах, бэхжүүлэх талаарх бусад улс орны туршлага, сургамжаас суралцах;
- Шинжлэх ухаан технологийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрдэмтэн, судлаачдад мэдлэг, чадвар, туршлагаа харилцан солилцох боломжийг бүрдүүлэх;
- Дэд бүтцийн салбарын бодлого боловсруулагчдад шинжлэх ухаан, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх.

Гурав. Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлаас дараах гол үр дүнг хүлээж байна. Үүнд:

- Хурлаас гамшигт тэсвэртэй дэд бүтцийг барьж байгуулах, бэхжүүлэхэд шинжлэх ухааны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, шинжлэх ухаанд суурилсан бодлого, шийдвэрийг гаргах аргазүйн талаар багц зөвлөмж гарна.
- Дахин болон шинээр төлөвлөж буй хотууд, дэд бүтцийг гамшигт тэсвэртэй төлөвлөх, байгуулах талаар бодлого боловсруулагчид, оролцогч талуудын болон орон нутгийн түвшний мэдлэг, ойлголт нэмэгдэнэ, шинжлэх ухааны үндэстэй нотолгоотой болно.
- Байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн дэд бүтцэд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг дээшлүүлэх арга замын талаар харилцан мэдлэг, туршлагаа хуваалцаж, талуудын хамтын ажиллагаа сайжирна.

Дөрөв. Хэлэлцэх асуудлын ерөнхий чиглэл

- Гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, гамшгийн эрсдэлийн засаглал
- Дэд бүтцийн аюулгүй байдал
- Нэн чухал дэд бүтцийг бий болгох хөтөлбөр, төлөвлөлт /тээвэр, эрүүл мэнд, эрчим хүч, харилцаа холбоо, г.м./
- Нэн чухал дэд бүтцийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, арга аргачлал

- Гамшигт тэсвэртэй дэд бүтцийн олон улсын стандарт, норм, дүрэм, түүнийг нутагшуулсан сайн туршлага
- гео мэдээлэлд суурилсан дэд бүтэц, түүний эрсдэл
- гамшигт тэсвэртэй дэд бүтцийн мэдлэг хуваалцах/холбогдох талуудын уялдааг хангах асуудал
- гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгоход байгальд суурилсан шийдэл
- гамшигт тэсвэртэй хот төлөвлөлт, дэд бүтэц ба гамшгийг даван туулахад өгөгдөл, технологи, инновацыг ашиглах нь
- гамшигт илүү тэсвэртэй маргаашийг бий болгоход өнөөдрийн хөрөнгө оруулалт
- орон нутгийн түвшинд гамшигт тэсвэртэй хотыг бий болгоход дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх арга зам Гамшигт тэсвэртэй байдлын мэдээллийн сан, технологи, инновацыг хуваалцах нь \улс орнуудын авч хэрэгжүүлж буй сайн туршлага\

Тав. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох эрдэм шинжилгээний өгүүлэл нь удирдамжийн 4-т заасан чиглэлийн хүрээнд бичигдсэн байх бөгөөд дор дурдсан шаардлагыг хангасан байна.

1. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцэд тавигдах шаардлага

- Өгүүлэл/илтгэлийн нэр
- Зохиогчдын овог, нэр; эрдмийн зэрэг, цол; байгууллага
- Хураангуй (Өгүүллийн агуулгыг товчлон 150-300 үгэнд багтаан бичнэ.)
- Түлхүүр үг (5-8 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна.)
- Оршил (судалгааны асуудал, үндэслэл, хэрэгцээ шаардлага)
- Судалгааны арга зүй, аргачлал
- Судалгааны үр дүн
- Хэлэлцүүлэг
- Дүгнэлт /санал, зөвлөмж/
- Номзүй

2. Эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэржүүлэлтэд тавигдах шаардлага
Өгүүллийг А4 хэмжээтэй 8-14 хуудаст багтаан дараах форматаар бичиж ирүүлнэ.

- Хэрэглээний программ: Microsoft Word
- Үсгийн фонд: Үндсэн өгүүлэл Times New Roman regular, өгүүллийн хураангуй Times New Roman *italic*
- Үсгийн өндөр: Гарчиг 14pt; зохиогчийн нэр, хураангуй 11pt, *italic*; ерөнхий агуулга, хүснэгтийн тайлбар, агуулга нь 12pt өндөртэй үсгээр бичигдсэн байна. График, диаграмм, зургийн тайлбарыг 11pt өндөртэй үсгээр бичнэ.
- Ашигтай талбайн хэмжээ (margins): Top 2 см, Bottom 2 см, Right 2 см, Left 2 см; мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ. Header, footer цэс ашиглахгүй, хуудасны дугаар тавихгүй, мөр хоорондын зай 1 байна. Өгүүллийн хураангуй болон түлхүүр үг нийтдээ нэг tab/догол мөр зайд бичигдэнэ.

- Бичвэр доторх зураг: 300-400 dpi-аас багагүй нягтшилтайгаар зургийн *.JPEG өргөтгөлтэй. Зургийн тайлбарыг зургийн дор, хүснэгтийн тайлбарыг хүнэгтийн дээр дугаарлан бичнэ.
- Бүх математик бичлэгүүд Equation программаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 10 pt өндөртэй байна. Томьёо нь дээд, доод талаасаа 10 pt зайтай байх ба мөр голлон бичигдэнэ.Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтанд бичнэ.
- Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, зохиолын нэрсийг тавих ба өгүүлэлд иш татсан дарааллаар нь дугаарлана. Өгүүлэлд ишлэл авсан номын дугаар, хуудсыг бичихдээ дунд хаалт [...]нд бичнэ. /APA/
- Өгүүллийг цахимаар ирүүлэх ба зохиогчийн зураг, товч танилцуулгыг хавсаргана.
- Өгүүллийн хураангуй, сэдэв, зохиогчийг монгол, англи хэл дээр /заавал/, өгүүллийг монгол эсвэл англи хэлээр ирүүлнэ.

Зургаа. Оролцогчдын хүрээ, бүртгэлийн хугацаа

Олон улсын болон дотоодын гамшгийн эрсдэлийг бууруулах, дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид, төрийн байгууллагын бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд оролцох боломжтой.

Хуралд оролцох хүсэлтээ 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор nidr@nema.gov.mn цахим хаяг болон <https://nema.gov.mn/icdri-2025> цахим холбоосоор орж бүртгүүлнэ.

Оролцогчид хуралд хэлэлцүүлэх удирдамжид заасан шаардлага хангасан өгүүлэл, илтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны дотор nidr@nema.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Холбоо барих мэргэжилтэн: д/ч Б.Хулан/94851779/, У.Молор/80813859/, а/д М.Бадамзаяа/88958975/.

---o0o---